



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/ЗЧС

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 06 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XIII хуралдааны 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний зардалд 19.000.000 (Арван есөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах, төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний зардалд зарцуулах 19.000.000 (Арван есөн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллаганы болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"-аас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажлыг Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН